<b>УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>15 417.4</b>	<b>17 607.5</b>	<b>16 033.7</b>	<b>- 8.9</b>
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	10 726.5	11 461.1	11 953.9	4.3
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	4 018.3	6 125.4	3 956.1	- 35.4
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	672.6	21.0	123.7	5.9**

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (2.5 дахин) их наяд төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолт 1.2 (2.8 дахин) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 462.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.8 (2.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 19.2 (6.8%) тэрбум төгрөгөөр, ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл 6.5 (34.4%) тэрбум төгрөгөөр, хувцас үйлдвэрлэл 12.9 (71.4%) тэрбум төгрөгөөр, арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1.9 (57.7%) тэрбум төгрөгөөр, тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл 0.3 (7.6 дахин) тэрбум төгрөгөөр, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 16.0 (91.3%) тэрбум төгрөгөөр, үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл 0.6 (6.7%) тэрбум төгрөгөөр, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 0.8 (21.8%) тэрбум төгрөгөөр, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл 0.5 (3.8 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Цахилгаан, хий, уур, агааржуулалт 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 339.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 89.7 (35.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2026 оны 1 дүгээр урьдчилсан гүйцэтгэлээр 16.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6 (8.9%) тэрбум төгрөгөөр буурахад хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах, дахин ашиглах 4.0 (35.4%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийслэлийн аж үйлдвэрийн салбар 2026 оны 1 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр 3.0 их наяд төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 72.5 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 18.9 хувийг, цахилгаан, хий, уур, агааржуулалт 8.1 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 0.5 хувийг тус тус эзэлж байна.

## АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, жил бүрийн эхний сарын байдлаар

ЗУРАГ 18.



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2026 оны 1 дүгээр урьдчилсан гүйцэтгэлээр 5.4 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.7 (3.2 дахин) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 3.5 (4.5 дахин) их наяд төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэл 0.9 (19.1%) их наяд төгрөгөөр, цахилгаан, хий, уур, агааржуулалт салбарын борлуулалт 89.7 (35.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Гадаад зах зээлд 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 4.3 их наяд төгрөгийн борлуулалт хийсний 4.2 их наяд төгрөг нь уул уурхайн, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 6.5 хувийг нүүрс олборлолтын салбар, 92.1 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 1.3 хувийг газрын түүхий тос, байгалийн хий олборлолтын салбар, 0.1 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.


**ХҮСНЭГТ 19.**

**АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар**

Салбар	Нийт борлуулалт			2026* I	Экспорт
	2024 I	2025 I	2026* I	2025 I	
	сая төгрөг			Хувь	
<b>БҮГД</b>	<b>1 703 252.9</b>	<b>1 715 354.7</b>	<b>5 415 195.1</b>	<b>3.1**</b>	<b>80.1</b>
<b>УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ</b>	<b>1 025 990.4</b>	<b>999 450.2</b>	<b>4 525 103.4</b>	<b>4.5**</b>	<b>94.8</b>
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	312 547.9	92 674.0	315 715.9	3.4**	88.5
Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт	99136.4	77 608.9	57 285.1	-26.2	100.0
Металлын хүдэр олборлолт	609 671.7	825 446.8	4 144 886.5	5.0**	95.3
Бусад ашигт малтмал олборлолт	2 496.7	18.3	3 253.9	17.7**	99.6
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	2 137.7	3 702.2	3 962.0	7.0	
<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ</b>	<b>469 932.2</b>	<b>448 287.3</b>	<b>533 962.5</b>	<b>19.1</b>	<b>9.1</b>
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	332 389.3	314 513.9	353 044.7	12.3	7.6
Мах боловсруулах, консервлох	65 848.1	58 688.9	55 353.8	-5.7	47.7
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	4 569.2	7 699.3	9 345.2	21.4	
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	48 051.7	47 658.8	56 881.2	19.4	
Үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	37 421.6	22 503.3	28 774.9	27.9	
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	51 871.6	58 764.5	64 155.9	9.2	
Малын тэжээл үйлдвэрлэл	1 432.3	448.0	506.0	12.9	
Ундаа үйлдвэрлэл	123 194.8	118 751.1	138 027.7	16.2	0.3
Тамхи үйлдвэрлэл	1 949.9	3 042.9	5 582.0	83.4	
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	19 924.6	15 891.1	21 030.5	32.3	79.3
Хувцас үйлдвэрлэл	13 990.5	17 736.4	18 041.0	1.7	6.7
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4 646.4	2 093.7	4 293.4	2.1**	39.9
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	33.9	40.0	376.5	9.4**	
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	9 290.5	8 834.4	8 915.9	0.9	
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	5 091.4	4 561.4	4 848.7	6.3	
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	12 500.0	10 241.4	15 073.0	47.2	
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21 781.1	10 883.1	39 532.2	3.6**	
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	9 614.2	10 152.8	13 687.1	34.8	0.3
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 888.2	8 286.5	8 082.1	-2.5	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	4 453.8	5 156.8	4 896.7	-5.0	
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	992.1	3 518.6	2 770.5	-21.3	77.1
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-	-	-	-	
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	19.3	184.0	733.2	4.0**	
Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	385.8	592.1	515.7	-12.9	
Тавилга үйлдвэрлэл	2 162.8	3 162.4	1 743.5	-44.9	
Бусад боловсруулах үйлдвэрлэл	2 590.1	2 344.6	2 864.4	22.2	1.1
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	19 228.3	27 051.2	27 931.4	3.3	
<b>ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ</b>	<b>192 250.7</b>	<b>250 060.6</b>	<b>339 783.3</b>	<b>35.9</b>	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	192 250.7	250 060.6	339 783.3	35.9	
<b>УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>15 079.6</b>	<b>17 556.6</b>	<b>16 345.9</b>	<b>-6.9</b>	
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	10 726.5	11 461.1	12 055.6	5.2	
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	4 073.3	6 056.5	4 166.6	-31.2	
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	279.8	39.0	123.7	3.2**	

**ЗУРАГ 19.**

**АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жил бүрийн I сарын байдлаар**



**Ойлголт, тодорхойлолт:**

**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:** Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

**Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс:** Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёог ашиглан тооцно.

**Тооцох аргачлал:** Ласпейрсийн биет хэмжээний индексийн томъёо:

Qt- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ  
 Q0- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ  
 P0- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ  
 W0-Жин

$$I_{LQ} = \frac{\sum(Q_t \cdot P_0)}{\sum(Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum\left(\frac{Q_t}{Q_0}\right) \cdot W_0 \cdot 100$$

**Ангилал, код:** Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал  
 Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал юм.



# БАРИЛГА

**Нийслэлийн барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.3 хувиар өслөө.**

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2025 онд 6143.1 тэрбум төгрөг болж, 5961.3 (97.0%) тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 181.8 (3.0%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажил 2025 онд өмнөх оноос 1701.7 (38.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын барилгын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 2124.3 (55.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

## ХҮСНЭГТ 20.

### БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, гүйцэтгэгчийн төрлөөр, жил бүрийн эцэст

Төрөл	2022	2023	2024	2025*	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
	сая төг					
<b>Нийт</b>	<b>2 926 188.5</b>	<b>3 676 256.9</b>	<b>4 441 460.7</b>	<b>6 143 113.7</b>	<b>1 701 653.0</b>	<b>38.3</b>
Дотоодын байгууллага	2 870 210.7	3 573 324.2	3 837 076.6	5 961 337.6	2 124 261.0	55.4
Төрийн	78 266.8	62 342.3	58 908.9	775 042.2	716 133.3	13.2**
Хувийн	2 770 142.5	3 486 460.4	3 760 135.4	5 152 332.3	1 392 196.9	37.0
Гадаадтай хамтарсан	21 801.4	24 521.5	18 032.3	33 963.1	15 930.8	88.3
Гадаадын байгууллага	55 977.7	102 932.7	604 384.1	181 776.1	- 422 608.0	- 69.9

Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 5152.3 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1392.2 (37.0%) тэрбум төгрөгөөр, төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их

засварын ажил 775.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 716.1 (13.2 дахин) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 34.0 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 15.9 (88.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

## ЗУРАГ 20.

### БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, жил бүрийн эцэст



Энэ онд гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын 2865.0 (46.6%) тэрбум төгрөгийг орон сууцны барилга, 1557.0 (25.3%) тэрбум төгрөгийг орон сууцны бус барилга, 1348.1 (22.0%) тэрбум төгрөгийг инженерийн барилга, байгууламж, 373.0 (6.1%) тэрбум төгрөгийг их засварын ажил эзэлж байна.

Өмнөх оны мөн үеэс орон сууцны барилга 558.7 (24.2%) тэрбум төгрөгөөр, орон сууцны бус барилга 517.4 (49.8%) тэрбум төгрөгөөр, их засварын ажил 439.7 (48.4%) тэрбум төгрөгөөр, инженерийн барилга, байгууламж 185.9 (99.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.


### ХҮСНЭГТ 21.

### ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГЭЭР, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ

Нийслэл, дүүрэг	2022	2023	2024	2025*	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
	сая төгрөг					
<b>Нийслэлийн дүн</b>	<b>2 870 210.7</b>	<b>3 573 324.2</b>	<b>3 837 076.6</b>	<b>5 961 337.6</b>	<b>2 124 261.0</b>	<b>55.4</b>
Багануур	25 796.1	19 225.7	37 974.5	82 736.5	44 762.0	2.2**
Багахангай	4 993.7	1 660.1	9 852.9	680 882.4	671 029.5	69.1**
Баянгол	196 193.1	280 644.0	404 893.3	501 528.3	96 635.0	23.9
Баянзүрх	680 994.4	748 875.5	666 632.2	843 172.8	176 540.6	26.5
Налайх	33 578.0	81 876.1	46 302.2	193 421.4	147 119.2	4.2**
Сонгинохайрхан	117 341.3	188 095.2	232 373.0	373 839.7	141 466.7	60.9
Сүхбаатар	320 325.0	359 453.7	494 947.4	635 686.0	140 738.6	28.4
Хан-Уул	1 421 353.6	1 757 626.0	1 816 936.5	2 352 796.2	535 859.7	29.5
Чингэлтэй	69 635.5	135 867.9	127 164.6	297 274.3	170 109.7	2.3**

### ЗУРАГ 21.


### ДОТООДЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, ДҮҮРГЭЭР, ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ



Улаанбаатар хотод 2025 онд 5961.3 тэрбум төгрөгийн дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн байна. 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр Хан-Уул дүүрэгт 2352.8 тэрбум төгрөг, Баянзүрх дүүрэгт 843.2 тэрбум төгрөг, Сүхбаатар дүүрэгт 635.7 тэрбум төгрөг, Сонгинохайрхан дүүрэгт 373.8 тэрбум төгрөг, Баянгол дүүрэгт 501.5 тэрбум төгрөг, Багануур

дүүрэгт 82.7 тэрбум төгрөг, Чингэлтэй дүүрэгт 297.3 тэрбум төгрөг, Налайх дүүрэгт 193.4 тэрбум төгрөг, Багахангай дүүрэгт 671.0 тэрбум төгрөгийн дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн байна.

**ЗУРАГ 22. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАВСРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГЭЭР, 2025 он**



**ХҮСНЭГТ 22.**

**АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, БАРИЛГЫН ТӨРЛӨӨР, жил бүрийн эцэст**

Барилгын төрөл	2022	2023	2024	2025	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
сая төг						
<b>Дүн</b>	<b>2 473 107.2</b>	<b>2 588 069.6</b>	<b>3 815 455.2</b>	<b>5 370 720.4</b>	<b>1 555 265.2</b>	<b>40.8</b>
Орон сууцны барилга	1 800 088.4	1 579 118.9	2 343 345.4	2 609 200.8	265 855.4	11.3
Орон сууцны бус барилга	351 261.4	571 135.4	828 577.5	1 225 946.4	397 368.9	48.0
Үйлдвэрийн	4 425.0	26 530.0	21 300.0	27 441.0	6 141.0	28.8
Худалдаа, үйлчилгээний	99 275.6	142 410.0	225 406.3	311 206.1	85 799.8	38.1
Эмнэлгийн	37 700.2	11 350.0	22 777.4	83 134.3	60 356.9	3.7**
Сургууль, соёлын	133 969.2	205 370.9	250 757.7	396 928.5	146 170.8	58.3
Бусад	75 891.4	185 474.5	308 336.1	407 236.5	98 900.4	32.1
<b>Инженерийн барилга, байгууламж</b>	<b>229 531.5</b>	<b>337 381.3</b>	<b>557 917.3</b>	<b>1 264 143.4</b>	<b>706 226.1</b>	<b>2.3**</b>
Эрчим хүчний	17 552.9	47 760.2	323 724.1	39 241.8	- 284 482.3	- 87.9
Холбооны		9 513.5	5 227.0	3 228.7	- 1 998.3	- 38.2
Авто зам	145 843.1	39 376.2	46 316.5	85 542.5	39 226.0	84.7
Гүүр, гүүрэн гарц	7 466.6	143 267.7	109 666.1	2 498.6	- 107 167.5	- 97.7
Далан, суваг, шугам, сүлжээ	17 252.6	37 433.4	7 350.6	967 759.5	960 408.9	131.2**
Зам, талбайн бусад ажил	41 416.3	60 030.3	65 633.0	165 872.3	100 239.3	2.5**
<b>Их засварын ажил</b>	<b>92 225.9</b>	<b>100 434.0</b>	<b>85 615.0</b>	<b>271 429.8</b>	<b>185 814.8</b>	<b>3.2**</b>

2025 онд улиралд ашиглалтад оруулсан барилга угсралт, их засварын ажил 5370.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1555.3 (40.8 %) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Үүнд, инженерийн барилга, байгууламж 706.2 (2.3 дахин) тэрбум төгрөгөөр, орон сууцны бус барилга 397.4 (48.0%) тэрбум төгрөгөөр, их засварын ажил 185.8 (3.2 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

**Ойлголт, тодорхойлолт**

**Барилга угсралт, их засвар:** Барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

**Орон сууцны бус барилга:** Барилгын багахан хэсгийг (нийт талбайн 50%-аас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.

**Инженерийн барилгын ажил:** Төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга байгууламжийн бүх ажлыг оруулна.

**Орон сууцны барилга:** Хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж юм.



# ХОТ НИЙТИЙН АЖ АХУЙ


**Нийслэлийн хэмжээнд борлуулсан нийт уснаас хүн амд 3.2 сая.м<sup>3</sup> (78.0%), аж ахуйн нэгж, байгууллагад 0.9 сая.м<sup>3</sup> (22.0%) цэвэр усыг борлуулжээ.**

2026 оны 1 дүгээр сард нийт 4.1 сая.м<sup>3</sup> цэвэр ус борлуулж, 5.5 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлжээ.


## ХҮСНЭГТ 23. УС СУВАГ АШИГЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 I	2025 I	2026 I	2026 2025
Шахсан ус	мянган м <sup>3</sup>	5 177	5 444	5 770	6.0
Борлуулсан ус	мянган м <sup>3</sup>	4 201	4 406	4 115	-6.6
Хүн амд	мянган м <sup>3</sup>	3 334	3 485	3 210	-7.9
Аж ахуйн нэгж, байгууллага	мянган м <sup>3</sup>	867	921	905	-1.8
Татан зайлуулсан бохир	мянган м <sup>3</sup>	4 260	4 499	4 190	-6.9
Хүн амаас	мянган м <sup>3</sup>	3 298	3 495	3 226	-7.7
Аж ахуйн нэгж, байгууллага	мянган м <sup>3</sup>	961	1 003	964	-4.0
Ус борлуулалтын орлого	сая төгрөг	5 587	5 838	5 529	-5.3
Хүн амаас	сая төгрөг	3 002	3 095	2 841	-8.2
Аж ахуйн нэгж, байгууллага	сая төгрөг	2 585	2 744	2 688	-2.0
Сувагжуулалтын орлого	сая төгрөг	4 432	4 640	4 356	-6.1
Хүн амаас	сая төгрөг	1 991	2 069	1 896	-8.4
Аж ахуйн нэгж, байгууллага	сая төгрөг	2 441	2 571	2 460	-4.3

## ЗУРАГ 23. БОРЛУУЛСАН УС



**ЗУРАГ 24. ТАТАН ЗАЙЛУУЛСАН БОХИР, сараар**



Цэвэрлэх байгууламжаар 4.1 сая.м<sup>3</sup> бохир цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн

4.2 сая.м<sup>3</sup> бохир шингэнийг татан зайлуулсан байна.

**Ойлголт, тодорхойлолт:**

**Шахсан ус:** Ус хангамжийн эх үүсвэрээс хотын ус хангамжийн төвлөрсөн сүлжээнд нийлүүлсэн усыг хэлнэ.

**Борлуулсан ус:** Хотын ус хангамжийн төвлөрсөн системээс хэрэглэгчийн тоолуураар болон ус түгээх байраар дамжуулан борлуулсан усыг хэлнэ.

**Татан зайлуулсан бохир:** Ус ариутгах татуургын шугамаар дамжуулан бохир ус цэвэрлэх байгууламжид хүлээн авсан бохир усыг хамруулна.

**Сувагжуулалтын орлого:** Хэрэглэгчийн тоолуураар болон бохир зөөврийн авто машинаар дамжуулан ариутгах татуургын системд хүлээн авч татан зайлуулсан үйлчилгээний орлогыг хамааруулна.



# ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

**Нийслэлийн агаарын дундаж хэм 2026 оны 1 дүгээр сард -4.1 °C байв.**

Нийслэлийн агаарын дундаж хэм 2026 оны 01 дүгээр сард -4.1 °C байгаа нь өмнөх оны мөн үеийн дундажтай харьцуулбал 13.3°C-аар

дулаан байв. Энэ сарын хур тунадасны нийлбэр 10.1 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 18 метр секунд хүрсэн байна.

## ХҮСНЭГТ 24. АГААРЫН БОХИРДОЛТ, I сард


Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий, мг/м <sup>3</sup>	SO <sub>2</sub>	0.050	440	0.271	138	0.047
Азотын давхар исэл, мг/м <sup>3</sup>	NO <sub>2</sub>	0.050	427	0.100	263	0.052
Тоосжилт, мг/м <sup>3</sup>	PM <sub>10</sub>	0.100	513	0.283	184	0.091
	PM <sub>2.5</sub>	0.050	490	0.386	356	0.068
Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м <sup>3</sup>	CO	10.000	369	9.600	79	2.288
Озон, мг/м <sup>3</sup>	O <sub>3</sub>	0.100	864	0.093	0	0.023

2026 оны 1 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад азотын давхар исэл

4 мкг/м<sup>3</sup>-ээр (7.0%), PM 10 тоосонцор 35 мкг/м<sup>3</sup>-ээр (27.0%), PM 2.5 тоосонцор 17 мкг/м<sup>3</sup> -ээр(19.0%), хүхэрлэг хий 77 мкг/м<sup>3</sup>-ээр (19.0%) тус тус бага байна.


## ЗУРАГ 25.

### УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГ ХИЙН АГУУЛАМЖ, 15 станцын дундаж, мг/м<sup>3</sup>




**ЗУРАГ 26.**

**УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ АЗОТЫН ДАВХАР ИСЛИЙН АГУУЛАМЖ, 16 станцын дундаж, мг/**



**ЗУРАГ 27.**

**УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ 10 МИКРОНООС БАГА ХЭМЖЭЭТЭЙ ТООСНЫ АГУУЛАМЖ, 16 станцын дундаж, мг/м3**



**ХҮСНЭГТ 25.**

**УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станц, 2026 оны I сард**

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> )	Азотын давхар исэл (NO <sub>2</sub> )	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоосонцор (PM <sub>10</sub> )	Тоосонцор (PM <sub>2.5</sub> )
<b>Нийт</b>	<b>138</b>	<b>263</b>	<b>79</b>	<b>184</b>	<b>356</b>
Мишээл экспо	8	3	0	4	1
Баруун 4 зам	0	27	0	6	26
Тахилт	2	23		18	16
13-р хороолол	0	21	0	2	25
Зуун айл	5	10	6	22	25
Цахилгаан станц	0	9	0	13	17
Ургах наран хороолол	22	16	0	8	25
Хайлааст	4	5	14	20	24
Таван буудал	10	15		17	
Богд хааны ордон музей	8	8	0	0	6
Шархад	7	26	15	16	18
Налайх	20	29	1	14	24
Яармаг	2	20	0	13	25
Нисэх			0	0	9
Толгойт	26	20	24	9	28
Зурагт		22	19	0	29
Амгалан		9		0	6
Дамбадаржаа				22	28
Баянхошуу	24				24

**Хүснэгт 26.**

**УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСЫН ХОНОГИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, мг/м3, I сард**

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл Экспо төв	Баруун дөрвөн зам	Тахилт	13-р хороолол	Зуун айл	Цахилгаан станц	Ургах наран хороолол	Хайлааст	Таван буудал
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	0.043	0.028	0.036	0.024	0.036	0.022	0.061	0.034	0.057
	Хамгийн их	0.128	0.05	0.055	0.039	0.061	0.044	0.142	0.072	0.163
	XXX*-с давсан %	26	0	9	0	16	0	71	13	32
	Хэмжилтийн тоо	31	31	23	31	31	27	31	31	31
Азотын давхар исэл NO <sub>2</sub>	Дундаж	0.021	0.065	0.058	0.057	0.042	0.043	0.05	0.044	0.054
	Хамгийн их	0.064	0.084	0.072	0.081	0.084	0.083	0.076	0.054	0.082
	XXX*-с давсан %	10	87	74	70	32	33	52	20	58
	Хэмжилтийн тоо	31	31	31	30	31	27	31	25	26
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.912	1.584		1.418	2.818	0.763	0.997	3.638	
	Хамгийн их	4	3.264		3.549	5.875	1.415	2.104	6.031	
	XXX*-с давсан %	0	0		0	19	0	0	45	
	Хэмжилтийн тоо	31	31		31	31	27	27	31	
Тоос PM <sub>10</sub>	Дундаж	0.063	0.072	0.132	0.06	0.137	0.114	0.083	0.152	0.125
	Хамгийн их	0.143	0.134	0.227	0.133	0.261	0.221	0.133	0.257	0.198
	XXX*-с давсан %	13	19	69	7	73	48	26	74	74
	Хэмжилтийн тоо	31	31	26	29	30	27	31	27	23
Тоос PM <sub>2.5</sub>	Дундаж	0.02	0.052	0.077	0.051	0.087	0.051	0.049	0.112	
	Хамгийн их	0.041	0.096	0.149	0.125	0.223	0.12	0.083	0.195	
	XXX*-с давсан %	3	84	84	81	86	63	81	100	
	Хэмжилтийн тоо	30	31	19	31	29	27	31	24	
Озон O <sub>3</sub> **	Дундаж	0.025			0.009	0.008				
	Хамгийн их	0.049			0.032	0.022				
	XXX*-с давсан %	0			0	0				
	Хэмжилтийн тоо	93			93	93				

үргэлжлэл

Агаарын бохирдлын үзүүлэлт		Богд хааны ордон музей	Шархад	Налайх	Яармаг	Нисэх	Толгойт	Зурагт	Дамбад аржаа	Баянхошуу
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	0.038	0.043	0.054	0.025		0.094			0.112
	Хамгийн их	0.116	0.075	0.084	0.067		0.159			0.271
	XXX*-с давсан %	29	23	0.064	6		87			92
	Хэмжилтийн тоо	28	30	31	31		30			26
Азотын давхар исэл NO <sub>2</sub>	Дундаж	0.046	0.06	0.077	0.058		0.058	0.06		
	Хамгийн их	0.064	0.079	0.1	0.08		0.078	0.078		
	XXX*-с давсан %	33	84	94	64		67	71		
	Хэмжилтийн тоо	24	31	31	31		30	31		
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	0.961	3.98	2.267	0.368	1.885	6.015	4.419		
	Хамгийн их	1.679	9.123	4.019	2	2.89	9.6	7.454		
	XXX*-с давсан %	0	48	3	0	0	80	61		
	Хэмжилтийн тоо	27	31	30	31	31	31	31		
Тоос PM <sub>10</sub>	Дундаж	0.05	0.116	0.093	0.089	0.035	0.084	0.057	0.131	
	Хамгийн их	0.094	0.283	0.152	0.163	0.061	0.127	0.098	0.202	
	XXX*-с давсан %	0	52	45	43	0	30	0	76	
	Хэмжилтийн тоо	31	31	31	30	31	30	31	29	
Тоос PM <sub>2.5</sub>	Дундаж	0.026	0.076	0.074	0.063	0.029	0.074	0.053	0.112	0.187
	Хамгийн их	0.056	0.214	0.136	0.103	0.047	0.114	0.089	0.18	0.386
	XXX*-с давсан %	24	82	77	81	29	93	84	97	100
	Хэмжилтийн тоо	25	22	31	31	31	30	31	29	24
Озон O <sub>3</sub> **	Дундаж		0.006	0.001	0.049	0.025	0.029	0.034		
	Хамгийн их		0.012	0.004	0.087	0.075	0.076	0.055		
	XXX*-с давсан %		0	0	0	0	0	0		
	Хэмжилтийн тоо		93	93	92	46	89	92		

### Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2026 оны 1 дүгээр сарын 07–08-ны өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд Амоны азот

21.2 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 17.4 дахин, нитритийн нэгдэл 16.6 дахин, эрдэс фосфор 5.5 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

### ХҮСНЭГТ 27. НИЙСЛЭЛИЙН ГАДАРГЫН УСНЫ НАЙРЛАГА, I сард

Үзүүлэлт	Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг		
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт	
Хүчилтөрөгч	O <sub>2</sub>	≥6	8.61	Хэвийн	0.79	2 дахин бага
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BХХ <sub>5</sub>	≤3	2.1	Хэвийн	55.2	17.4 дахин
Нитритийн нэгдэл	NO <sub>2</sub>	≤0.02	0.004	Хэвийн	0.215	16.6 дахин
Амоны азот	NH <sub>4</sub>	≤0.5	0.02	Хэвийн	24.64	21.2 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.002	Хэвийн	1.368	5.5 дахин

### Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2026 оны 1 дүгээр сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 86 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 86.0 хувийг ан амьтны зөрчил, 7.0

хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 5.8 хувийг ойн зөрчил, 1.2 хувийг усны зөрчил байна. Илрүүлсэн нийт зөрчилд 26.9 сая төгрөгийн торгууль ногдуулжээ.

### ХҮСНЭГТ 28 БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗӨРЧИЛ

Илрүүлсэн зөрчил, Төрлөөр	2026 I		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (мян төгрөг)
Бүгд	86	86	26 850.0
Ой	5	5	250.0
Ан, амьтан	74	74	22 300.0
Газрын	-	-	-
Ус	1	1	1 500.0
Ургамал, хөрсний бохирдол			
Агаар, химийн хорт бодис			
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай			
Геодези зураг зүй, кадастр			
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	6	6	2 800.0
Бусад			

### Аюулт үзэгдэл, осол:

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2026 оны 1 дүгээр сард 13 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 29.0 хувиар буурсан байна.

Гамшгийн улмаас 3 хүн амь насаа алдаж, 15 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 697.7 сая төгрөг зарцуулжээ.

2026 оны 1 дүгээр сард 196 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 29.0 хувиар буурсан байна. Гал түймрийн улмаас 6 хүн түлэгдэж гэмтэн, 2

хүн эндсэн байна. Худал дуудлага 13 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 44.1 хувиар өссөн байна.

Гал түймрийн аюулаас 68 хүн, 62 байшин барилга, 26.0 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал санамсаргүй

байдлаас 113 (57.7%), цахилгаанаас 68 (34.7%), санаатай үйлдлээр 3 (1.5%), бусад шалтгаанаар 11 (5.6%), шалтгаан тодорхойгүй 1(0.5%), гал түймэр гарчээ.

## ХҮСНЭГТ 29. ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, ДҮҮРГЭЭР, ЖИЛ БҮРИЙН I САРЫН ЭЦЭСТ

Дүүрэг	2024 I	2025 I	2026 I	2026 2025
				Хувь
<b>Нийслэлийн дүн</b>	<b>257</b>	<b>276</b>	<b>196</b>	<b>-29.0</b>
Багануур	3	5	4	-20.0
Багахангай	1	1	1	0.0
Баянгол	19	29	18	-37.9
Баянзүрх	73	65	61	-6.2
Налайх	10	15	4	-73.3
Сонгинохайрхан	64	63	45	-28.6
Сүхбаатар	26	29	19	-34.5
Хан-Уул	36	43	23	-46.5
Чингэлтэй	25	26	21	-19.2

Гал түймэрт 87 гэр, орон сууц, 9 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 22 машин техник, 49 малын хашаа саравч, бусад төрлийн 29 объект өртжээ. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 151, төрийн өмчийн 28, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 17 объект өртөж, нийт 669.8 сая төгрөгийн хохирол учирсан байна. Нийслэлийн Онцгой байдлын газраас

2026 оны 1 дүгээр сард 22 барилгын зураг төсөл, ашиглалтад хүлээн авч буй 25 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 1936 объектод үзлэг шалгалт хийж, 1839 галын зөрчил илрүүлж, байгууллага, албан тушаалтан, иргэнд 230 заавал биелүүлэх албан шаардлага, 218 мэдэгдэл хүргүүлж, 29.4 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

### Ойлголт, тодорхойлолт

**Агаарын бохирдол:** Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

**Аюулт үзэгдэл:** Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

**Гамшиг:** Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа,

дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

**Зөвшөөрөгдөх түвшин:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

**Хүлцэх агууламж:** Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

# БҮЛЭГ

## ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2021-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	
I	Эрүүл мэнд	П.Тогтохбаяр
II	Гэмт хэрэг	Я.Оролжидсүрэн
III	Төсөв	Д.Оюунгэрэл
IV	Хэрэглээний үнэ	Б. Элбэгдорж
V	Мал аж ахуй	З.Халиун
VI	Аж үйлдвэр	Ц.Соёл-Эрдэнэ
VII	Барилга	Х.Азжая
VIII	Хотын нийтийн аж ахуй	П.Тогтохбаяр
IX	Цаг уур, агаарын чанар, аюулт үзэгдэл, осол	П.Тогтохбаяр



## Авлигатай тэмцэх газар

### Хэрэв танд:

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу;

### Үүнд:

22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;

22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;

22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хохууль авах/;

22.5 дугаар зүйл /Хохууль өгөх/;

22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хохуульдах/;

22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;

22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;


22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;

22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/;

22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;

22.13 дугаар зүйл /Хохууль авах/;

### ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/



Авлигыг мэдээлэх утас

### ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ Хүлээн авах суваг

Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн

Утсаар: (976)-110 /Ярианы төлбөргүй/

дугаараар

Факс: (976)-11-311919

Цахим шуудангийн хаяг: [contact@iaac.mn](mailto:contact@iaac.mn)

Шуудан холбоогоор: Улаанбаатар хот 14250,

Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн

удамж 41 хаягаар

Веб сайт: [iaac.mn](http://iaac.mn)

Авлигын эсрэг



Үгүй гэж хэлээд өөрчилъе! 110

